



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 27 өдөр

Дугаар

4/411

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны “Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай” 479 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын хяналтын хуудасны нэр, кодыг нэгдүгээр, хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх хяналтын хуудсыг чиглэл бүрээр хоёроос зугаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналтын хуудсыг хяналт шалгалтад хэрэглэх, Улсын (ахлах) байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Салбарын хяналтын газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, нийслэлийн Соёл, урлагийн газар, Аялал жуулчлалын газар, аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Номын сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн баталсантай холбогдуулан Соёлын сайдын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “Хяналтын хуудас батлах тухай” А/219 дүгээр тушаалаар баталсан 5.2.1 кодтой хяналтын хуудсыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Түмэндэмбэрэл)-т үүрэг болгосугай.



Ч. УНДРАМ

14190010934

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын
яамны Төрийн нарийн бичгийн даргын
2025 оны // дугаар сарын // ны өдрийн
// нэг дүгээр тушаалын хавсралт



САЛБАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ НЭР, КОД

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр
1	5.3.2	Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
2	5.2.1	Номын сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
3	5.5.1	Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
4	5.6.1	Усан бассейн, чийрэгжүүлэлтийн усан сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
5	5.6.2	Чийрэгжүүлэх, бялдаржуулах төвийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас